

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Улсын Их Хурал 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д “төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно,” гэж заасан бөгөөд Үндсэн хуулийн энэхүү нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг 2020 оны 5 дугаар сарын 7-ны өдөр шинэчлэн баталсан билээ.

1. Үндсэн хуулийн энэхүү нэмэлт, өөрчлөлтийн үндсэн үзэл баримтлал нь төр хөгжлийн нэгдсэн бодлоготой байж, тэр нь урт хугацаандаа тогтвортой хэрэгжиж, салбар, бүс орон нутгийн түвшинд бодлого нь уялдаа холбоотой байж, урт, дунд, богино хугацаандаа бодлого нь тогтвортой хэрэгждэг байх, улс, орон нутгийн төсөв нь хөгжлийн бодлого, зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн төсөв байх үндсэн үзэл санаагаар оруулсан өөрчлөлт юм. Иймд, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.” гэж заагаад, улмаар 6.10.1-д “Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, ... Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байна” гэж, 6.10.2-д “санхүүжилтийн баталгаат эх үүсвэртэй, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан тухайн жилд хэрэгжих төсөл, арга хэмжээний задаргаа байна” гэж, мөн 6.10.3-т “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.” гэж, 6.10.4-т “орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна” гэж тус тус заасан.

Улмаар энэхүү зарчмын өөрчлөлтийг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор 2020 оны 5 дугаар сарын 7-ны “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 45 дугаар тогтоолыг баталж, түүний 4 дэх заалтад:

“Төсвийн тухай болон холбогдох бусад хуулийг энэ хуульд нийцүүлэн боловсруулж, Улсын Их Хуралд 2020 оны 10 дугаар сарын 01-ний дотор өргөн мэдүүлэх;”-ийг Засгийн газарт үүрэг болгосон. Гэвч, Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын үндсэн үзэл баримтлал, түүнд нийцүүлэн баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн суурь зарчим хэрэгжихгүй байдал үргэлжилсэн тул 2020 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн Улсын Их Хурлын даргын 51 тоот захирамжаар “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсэг” байгуулсан юм.

Тус ажлын хэсэг 2 сарын хугацаанд ажиллаж, бүх яамдын сайд нар, бүх аймаг болон нийслэлийн Засаг дарга нартай хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг судалж, таван чиглэлээр санал, дүгнэлт гаргасан байна. Түүнчлэн ажлын хэсгийн ажиллах хугацаанд 13 яам, 21 аймгийн Засаг даргаас тодорхой саналууд ирсэн. Тэдгээр саналын хүрээнд урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл боловсруулахад хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах саналыг ирүүлсний дагуу холбогдох зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах шаардлага үүссэн болно. Үүнд:

- “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлахаар хуульд тусгах;
- “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлахаар хуульд тусгах;
- цаг үеийн тулгамдсан, зайлшгүй асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай эрсдлийн үеийн төсөл, арга хэмжээг Улсын Их Хуралд танилцуулснаар төлөвлөгөөндөө тусгах боломжийг хуульчлах;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалтай холбоотой төрийн дотоод бодлогын баримт бичиг болон гамшиг, онц, дайны байдлын үеийн төлөвлөгөөний статусыг тодорхой болгох;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагыг боловсронгуй болгох;
- төсвийн бодлогыг хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулах, бодлогын баримт бичгийг тайлагнахдаа бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах хуулийн зохицуулалтыг тодорхой болгох шаардлага үүссэн.

2.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн батлах үндсэн шалтгаануудын нэг бол хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан институтын болон тус харилцаанд оролцогчдын чиг үүргийг уялдуулан зохицуулсан нэгдсэн тогтолцоо бий болгох асуудал байсан. Үүний хүрээнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэн батлахдаа 14 тодорхой оролцогчийг нэрлэн зааж, чиг үүргийг нь нэг бүрчлэн хуульчилж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлаар салбар дундын шууд удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий бие даасан яамтай байхаар хуульчилсан. Гэвч 2020 оны 7 дугаар сарын 7-ны өдөр үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудал, чиг үүргийн уялдааг нарийвчлан судлах зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай болон Засгийн газрын тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн бодлогын харилцан уялдааг хангах, салбар дундын болон орон нутгийн бодлогыг зангидсан яам байгуулах асуудал түр хойшлогдсон.

Үүний улмаас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаас хойш нэг жил, хууль шинэчлэн баталснаас хойш 8 сар, урт хугацааны хөгжлийн бодлого баталснаас хойш 8 сарын нүүр үзэж байгаа ч салбарууд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудалд нэгдсэн арга зүйгээр хангагдаж чадаагүй, холбогдох байгууллагууд хуулиа нэг мөр ойлгож, хэрэгжүүлж хэвшээгүй болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь техник, тоног төхөөрөмж, программ хангамж болон ур чадвартай хүний нөөц, хөгжлийн шаардлагатай тооцоо судалгааны баазын хувьд дутагдалтай хэвээр байгаа нь мэргэжлийн байгууллага, зөвлөх, судлаачдаас ирүүлсэн албан бичиг, судалгаа, дүгнэлт болон салбар, орон нутгийн удирдлагуудтай хийсэн хэлэлцүүлгээс тодорхой болсон.

Энэ үндэслэлээр Улсын Их Хурал 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолын 5 дахь заалтад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог сайжруулах, хариуцсан байгууллагын эрх зүйн байдал, зохион байгуулалт, чиг үүрэг болон тогтолцооны дотоод үйл ажиллагааг хангах хүчин зүйлийг оновчтой тогтоох, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дэд бүтэц хоорондын хамаарал, төр-хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг тодорхойлон, төрийн захиргааны төв байгууллага байгуулах талаарх зураглал гарган, шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэхээр заасан.

Иймд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулж, чиг үүргийг нь оновчтой зохион байгуулах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дэд бүтцүүдийн хоорондын уялдаа хамаарлыг нарийвчлан гаргах, энэхүү тогтолцооны дотоод үйл ажиллагааг хангах хүчин зүйлсийг оновчтой тодорхойлохын зэрэгцээ төрийн, улс төрийн, төсөв, санхүүгийн бусад тогтолцоотой хэрхэн уялдуулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг тодорхойлох хэрэгцээ, шаардлага үүссэн.

Иймд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд дээрх асуудлуудыг нэмж зохицуулах хэрэгцээ, шаардлага үүссэн болно.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, хамрах хүрээ, зохицуулах харилцаа

Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-т заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах бөгөөд тус төсөл нь дараах харилцааг зохицуулна:

- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн тайлагнах зарчмыг хуульчлах,
- Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын үзэл санаанд нийцүүлсэн төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчмыг хуульчлах;

- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний тухай холбогдох зохицуулалт нэмж тусгах;
- “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний тухай холбогдох зохицуулалт нэмж тусгах;
- цаг үеийн тулгамдсан, зайлшгүй асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай эрсдлийн үеийн төсөл, арга хэмжээг Улсын Их Хуралд танилцуулснаар төлөвлөгөөндөө тусгах боломжийг хуульчлах;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалтай холбоотой төрийн дотоод бодлогын баримт бичиг болон гамшиг, онц, дайны байдлын үеийн төлөвлөгөөний статусыг тодорхой болгох;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагыг боловсронгуй болгох;
- Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгуулах хууль зүйн үндсийг тогтоох, энэхүү яамыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Монгол Улсын Шадар сайдын тэргүүлэх, түүний эрхлэх асуудлын хүрээ хязгаарыг тогтоох;
- Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөлийн дэргэд салбар бүрийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлаар мэргэшсэн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үндэсний зөвлөл байгуулах;
- Тус зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах журмыг Улсын Их Хурлын даргын дэргэдэх Зөвлөл батлахаар төслийг боловсруулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл боловсруулах үйл ажиллагаа ойлгомжтой болно. Түүнчлэн Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад тавигдах шаардлага, зарчмыг сайжруулах нөхцөл бүрдэнэ.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбарын хэмжээнд шууд удирдан зохион байгуулах, хариуцан хэрэгжүүлэх яам байгуулж, чиг үүргийг нь оновчтой хуваарилснаар нэгдсэн удирдлага, арга зүйгээр дутагдаж, удаашраад буй Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг Үндсэн хууль болон Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн нэгтгэн боловсруулах ажил тууштай хийгдэх, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн аливаа асуудлыг нэгдсэн, ойлгомжтой удирдлагаар хангах зэрэг эерэг үр дүн авчирна.

Дөрөв.Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн талаар

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн

газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт өргөн мэдүүлнэ. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Монгол Улсын Шадар сайдын тэргүүлэхээр өөрчлөх, тус сайдын эрхлэх асуудлыг тодорхойлно.

Хууль санаачлагч